



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033

Утас: (976) 7035 9826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.16 № 107
танай _____-ны № _____-т

**2025 оны санхүүгийн тайлангийн
аудитын тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг түүвэрт хамруулан, баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар илэрсэн 2 зөрчилд зөрчлийн асуудлын бүртгэл хөтлөн баталгаажуулж, 9,345.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, гэрээний хэрэгжилт, хяналттай холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгч байна. Үүнд:

Албан шаардлага

Илрүүлэлт: Тайлант онд спортын заалны түрээсийн иргэн, аж ахуйн нэгжээс авах 9,345.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж

Илрүүлэлт: Түрээсийн гэрээ байгуулалт, гэрээний биелэлт, төлбөр барагдуулалтад дотоод хяналт хэрэгжээгүй, хяналт алдагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; 16.5.4.төсвийн байгууллагын үйл

612505346

ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;” гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээнд заасан хугацаанд спорт заалны түрээсийн төлбөрийг авч байх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлж албан шаардлага зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА